



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 126

Ховд

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2017-2018 онд хийгдсэн Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр гаргасан инженерийн хийцтэй хавсралтанд тусгагдсан Алтай, Цэцэг, Чандмань, Мөст, Манхан, Зэрэг сумдын 6 худгийн 101550000 төгрөг /нэг зуун нэг сая таван зуун тавин мянга/-ийн балансын үнэтэй худгийг үндсэн хөрөнгийг балансад бүртгэхийг Алтай сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Баатарсүрэн/, Цэцэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Билэгт/, Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Ганзориг/, Мөст сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Соёлмаа/, Манхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Ядамжав/, Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга /М.Баярт/ нарт зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэн, ашиглалтыг хариуцан ажиллахыг Алтай сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Баатарсүрэн/, Цэцэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Билэгт/, Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Ганзориг/, Мөст сумын Засаг

даргын Тамгын газрын дарга /Х.Соёлмаа/, Манхан сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Ядамжав/, Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын дарга /М.Баярт/ нарт үүрэг болгосугай.


3. Энэхүү тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны  
/26 дугаар тогтоолын хавсралт



СУМДЫН ЗДТГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ 2017-2018 ОНУУДАД  
ШИНЭЭР БАРИГДСАН ХУДГИЙН ЖАГСААЛТ

/ төгрөгөөр /

№	Сум, багийн нэр	Худгийн нэр	Худгийн гүн/м	Зардлын нэр, төрөл			
				Гэрээний дагуу 1м-ийн үнэлгээ	Худгийн цооногийн ажлын дүн	Худгийн барилга, тоног төхөөрөмжийн үнэ	Нийт төсөвт өртөг
<b>2017 он</b>							
1	Алтай сум Алтангадас баг	Үнсний үзүүр	85	130,000	11,050,000	7,500,000	18,550,000
2	Цэцэг сум Хажинга баг	Баднаанямбуугийн худаг	87	130,000	11,310,000	7,500,000	18,810,000
3	Чандмань сум Жаргалант баг	Цагаан хөв	48	130,000	6,240,000	7,500,000	13,740,000
<b>2017 оны нийт дүн</b>							<b>51,100,000</b>
<b>2018 он</b>							
5	Мөст сум Баянхайрхан баг	Тавтын Баянбулагын ам	60	130,000	7,800,000	7,500,000	15,300,000
6	Манхан сум Ботгон баг	Баазын худаг	120	130,000	15,600,000	7,500,000	23,100,000
7	Зэрэг сум Хөндлөн баг	Дэлийн адагт	35	130,000	4,550,000	7,500,000	12,050,000
<b>НИЙТ ДҮН</b>							<b>50,450,000</b>
<b>НИЙТ ДҮН</b>							<b>101,550,000</b>
<b>НИЙТ ДҮН</b>						<b>/нэг зуун нэг сая таван зуун тавин мянга/</b>	

.....000.....



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 127

Ховд

Нээлттэй дуудлагын худалдаа  
зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 31.3, дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь заалт аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашинуудын худалдах доод үнийг хавсралтаар баталсугай.

2.Нээлттэй дуудлагын худалдааг аймгийн Нутгийн удирдлагын ордонд болон хөрөнгө байрлаж буй тухайн орон нутагт нь 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсугай.

3.Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны  
12-дугаар тогтоолын хавсралт



ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДААЛАХ АВТОМАШИН, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛИЙН  
ҮЗҮҮЛЭЛТ ХУДАЛДАХ ДООД ҮНЭ

/төгрөгөөр/

№	Эзэмшигч байгууллагын нэр	Худалдах хөрөнгийн нэр,марк	Үйлдвэрл эсэн он	Ашиглал танд орсон он	Ашиглалтын талаархи мэдээлэл					Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Худалдах доод үнэ	Хаана болох
					А/жил	Улсын дугаар	Өнгө	Арлын дугаар	Хөдөлгү үрийн дугаар					
1	Мөст сумын ЗДТГ	Ланд круйзер-80	1995	2010	9	9986УНЦ	саарал	FZJ800116949	1fZ	28,000,000	28,000,000	-	1,000,000	Нутгийн удирдлагын ордон
2	Цагдаагийн газар	УАЗ Фургон	2012	2012	7	0075ХОУ	Хар	374100C0473653	410400C0	20,600,000	20,600,000	-	800,000	Нутгийн удирдлагын ордон
3	"Мянган Угалзат" ОНӨААТҮГ	Hyundai Fronter	1999	2012	7	4679ХОУ	ногоон	knpsd0122xs450985	1375589	8,000,000	8,000,000	-	300,000	Нутгийн удирдлагын ордон
4	Ховд сумын ЗДТГ	УАЗ-315120	2013	2013	6	4235ХОУ	Цагаан саарал	315100D006460	40210D006460	26,490,000	26,490,000	-	1,000,000	Нутгийн удирдлагын ордон
5	БСУГ	УАЗ Фургон	2011	2011	9	0280ХОА	Цагаан саарал	374100B0449463	B0001892	21,500,000	21,500,000	-	500,000	Нутгийн удирдлагын ордон
6	Цагдаагийн газар	Ланд круйзер-80	1995	2006	13	6003ХОУ	Цагаан саарал	FZJ800116949		81,110,000	81,110,000	-	2,000,000	Нутгийн удирдлагын ордон
7	Цэцэг сумын ЕБС	УАЗ-фургон	2012	2012	7	3549ХОУ	бор ногоон	374100C3029083	409100C3029083	25,300,000	25,300,000	-	500,000	Цэцэг сумын ЗДТГ
8	Булган сумын Өрхийн эрүүл мэндийн төв	Тоёото Субару	1993	2011	8	1481УБЯ	саарал	GC3AR0EK002868	930097	5,000,000	5,000,000	-	250,000	Булган сумын ЗДТГ
9	Буянт сумын ЗДТГ	Ланд круйзер-100	2000	2014	5	0068ХОУ	ногоон	JT111TJA008017554		30,000,000	30,000,000	-	2,000,000	Нутгийн удирдлагын ордон
10	Зэрэг сумын ЗДТГ	Ланд круйзер-105	2013	2013	6	0012УНЯ	цэнхэр	JT111TJA008017555		50,000,000	50,000,000	-	2,000,000	Зэрэг сумын ЗДТГ-т

.....оОо.....



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 128

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар  
өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Соёлын гавьяат зүтгэлтэн”- ээр

1. Сүрэн Бүрнээ - Мөнххайрхан сумын Сэнхэр багийн өндөр настан

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”- гоор

1. Эрхэмбаяр Дуламсүрэн - Мөнххайрхан сумын Сэнхэр багийн иргэн
2. Дандар Бэдээ - Мөнххайрхан сумын Хаг багийн иргэн

“Алтангадас одон”- гоор

1. Ишээ Олзвой - Мөнххайрхан сумын Борт багийн иргэн
2. Хөөвч Лождоо - Мөнххайрхан сумын Хаг багийн өндөр настан
3. Ёндон Галбадрах - Мөнххайрхан сумын Хаг багийн малчин
4. Чоймбол Оюун - Мөнххайрхан сумын Хаг багийн малчин
5. Лхамжав Зулзгана - Мөнххайрхан сумын Алаг багийн малчин
6. Гомбожав Балжинням - Мөнххайрхан сумын Алаг багийн өндөр настан
7. Тогмид Жамба - Мөнххайрхан сумын Алаг багийн малчин

- |                           |                                      |
|---------------------------|--------------------------------------|
| 8. Дамдин Машлай          | - Манхан сумын Баянгол багийн малчин |
| 9. Ширнэн Чулуунжав       | - Манхан сумын Баянгол багийн малчин |
| 10. Навхаан Хумбаа        | - Манхан сумын Баянгол багийн малчин |
| 11. Хандсүрэн Гантулга    | - Манхан сумын Баянгол багийн малчин |
| 12. Пунсанхорлоо Баянмөнх | - Манхан сумын Баянгол багийн малчин |

“Хөдөлмөрийн хүндэт медаль” - иар

- |                            |  |
|----------------------------|--|
| 1. Норсүрэн Бүүвэйбаатар   | - Мөнххайрхан сумын Борт багийн малчин                           |
| 2. Ууган Долгорсүрэн       | - Мөнххайрхан сумын Хаг багийн малчин                            |
| 3. Манж Наранчимэг         | - Мөнххайрхан сумын Ерөнхий боловсролын<br>сургуулийн багш       |
| 4. Зурман Нарантуяа        | - Ховд их сургуулийн багш  |
| 5. Даваа Цэнд- Алтай       | - Мөнххайрхан сумын Ерөнхий боловсролын<br>сургуулийн үйлчлэгч   |
| 6. Түвшинхүү Цэндсүрэн     | - Мөнххайрхан сумын Ерөнхий боловсролын<br>сургуулийн номын санч |
| 7. Батаа Энхцэцэг          | - Мөнххайрхан сумын Цэцэрлэгийн хөгжмийн багш                    |
| 8. Эрхэмбаяр Долгорсүрэн   | - Мөнххайрхан сумын Цэцэрлэгийн багш                             |
| 9. Ноосонхорхой Буянтогтох | - Мөнххайрхан сумын эрүүл мэндийн төвийн дүн<br>бүртгэгч         |
| 10. Сүх Энхжаргал          | - Мөнххайрхан сумын эрүүл мэндийн төвийн ээлжийн<br>сувилагч     |
| 11. Батмагнай Цогзолмаа    | - Мөнххайрхан сумын эрүүл мэндийн төвийн ээлжийн<br>сувилагч     |
| 12. Цандэлэг Бурмаа        | - Мөнххайрхан сумын эрүүл мэндийн төвийн үйлчлэгч                |

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 129

Ховд

Ажлыг дүгнэж урамшуулал  
олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 08 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.2.9, 4.2.10 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

- 1.Хөшөөт хөгжил сангийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 онд хийсэн ажлыг дүгнээд зөвлөлийн гишүүдэд ажлын үр дүнгээр урамшуулал олгосугай.
- 2.Урамшууллын зардалд 5000000 төгрөг /таван сая/-өөр тооцож олгохыг Хөшөөт хөгжил сангийн гүйцэтгэх захирал /Т.Мягмардорж/-д зөвшөөрсүгэй
- 3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

0000300